"Бүх нийт боловсролын төлөө!"
Иргэний нийгмийн үндсэн эвсэл

# Сургуулийн орчин, дотуур байр дахь хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээний аргачлал

**Улаанбаатар**
**2024 он**

**Зөвлөх:** Х.Баасанжаргал (“Хүний эрх - Дэвшилтэт бодлогын хүрээлэн”-гийн захирал, хүүхдийн эрхийн хуульч)

**Боловсруулсан:**

Г.Ганцэцэг (Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбооны зохицуулагч)
Я.Мөнхчимэг (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн дэд зохицуулагч)
А.Отгончимэг (Монголын багш, эцэг эхийн холбооны гүйцэтгэх захирал )
Б.Оюундарь (“Хөөрхөн зүрх” ТББ-ын зохицуулагч)

**Туршин, зөвлөмж боловсруулсан:**
Б.Мөнхжаргал (Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн)
Н.Нямдорж (ШУТИС-ийн Нийгмийн ажлын хөтөлбөр хариуцсан дэд профессор, доктор)

***Боловсролын төлөө чанга дуугарцгаая! төслийн санхүүжилтээр боловсруулав.***

**Агуулга**

**Удирдамж**

Үндэслэл

Нэр томьёоны тайлбар

Үнэлгээг хийхэд баримтлах зарчим

Товчилсон үг

**Нэгдүгээр хэсэг: Үнэлгээ хийх бэлтгэл**

1. Сургуулийн удирдлага, хамт олонд мэдээлэл өгөх
2. Үнэлгээний баг байгуулах
3. Ойлголт нэгтгэх семинар зохион байгуулах
4. Үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулах

**Хоёрдугаар хэсэг: Үнэлгээ хийх**

1. Материаллаг орчны үнэлгээ хийх
2. Нийгэм-сэтгэл зүйн орчны үнэлгээ хийх
3. Засаглалын орчны үнэлгээ хийх

**Гуравдугаар хэсэг: Үнэлгээний дүнг нэгтгэх, зөвлөмж боловсруулах**

**Хавсралтын жагсаалт:**

Материаллаг орчны үнэлгээний хуудас:

- Сургуулийн орчин
- Дотуур байрны орчин

Нийгэм-сэтгэл зүйн орчны үнэлгээний хуудас:

- Сурагчдаас авах ганцаарчилсан ярилцлагын хуудас
- Сургуулийн багш, ажилтнаас авах ганцаарчилсан ярилцлагын хуудас
- Асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдээс авах ганцаарчилсан ярилцлагын хуудас
- Дотуур байранд нэмэлтээр үнэлгээ хийх хуудас
- Сурагчдаас авах бүлгийн ярилцлагын хуудас

Засаглалын орчны үнэлгээний хуудас

- Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг үнэлэх хуудас
- ЕБС, дотуур байрын орчинд суралцагчийг үе тэнгийхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийн хэрэгжилтийг үнэлэх хуудас

**Үндэслэл**

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь (Боловсрол эвсэл) боловсролын чанар, санхүүжилтэд хяналт тавьж, уг салбарын хариуцлагын тогтолцоог иргэдийн оролцоотойгоор сайжруулах чиглэлээр боловсролын бодлогод нөлөөлөн хамтран ажиллах, үндэсний хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулах зорилгоор 2010 онд байгуулагдаж, өнөөг хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Боловсрол эвсэл 1. Боловсролын засаглалыг сайжруулах, 2. Боловсролын орчин дахь (дотуур байрыг оролцуулан) хүүхэд хамгааллыг сайжруулах стратегийн зорилгын хүрээнд гишүүн байгууллагын төлөөллүүдтэй хамтран сургуулийн орчинд хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх үнэлгээний аргачлалыг боловсрууллаа.

Энэхүү үнэлгээний аргачлалдаа Хүүхдийн эрхийн тухай хууль[1], Хүүхдийн эрхийн конвенц[2], НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн Газрын 5-р илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмж[3], ЕБС, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам[4], ЕБС, СӨБ, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм[5] болон 2024 оны 1 сард батлагдан 9 сарын 1-ий өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга) -ийг  удирдлага болгож ажиллалаа.

**Нөхцөл байдал (судалгааны тойм)**

“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа”[6]-г 2023 онд БШУЯ, ХНХЯ, ЭМЯ хамтран хийж олон нийтэд танилцуулсан. Уг судалгаа нь 3284 хүүхдийг хамарсан үндэсний хэмжээний төлөөлөлтэй түүвэр судалгаа бөгөөд 13-17 насны дунд ахлах ангийн сурагчдыг хамруулсан.  Судалгаанд оролцсон суралцагчдын 73,1 хувь нь сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдаагүй хэмээн хариулсан. *Хотын хүүхдүүдийн сургуульд ирж очих замдаа саад бэрхшээлтэй тулгарах байдал нь хөдөө орон нутгийн хүүхдүүдээс 10 хувиар илүү байна.* Сургуулийн орчинд спорт, урлагаар хичээллэх орон зай, анги танхим, зай талбайн хүрэлцээгүй байдал нь хичээлээс гадуур хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа судалгаанд хамрагдсан хүүхдийн 40 хувьд нөлөөлжээ. Нийгмийн сүлжээ, интернэтээс өсвөр насныхны 60.3 хувь өөрт хэрэгтэй мэдээллээ авч байгаа бөгөөд хотын хүүхдүүд хөдөөгийн хүүхдүүдээс  13 хувиар илүү байна. Хүүхдүүд өөрт хамааралтай асуудлаар санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргалтанд нөлөөлөх боломж хангалтгүй байна. Сайн дурын ажилд оролцсон байдал 45 хувь, хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс 9 хувиар илүү.

Өсвөр насанд шилжиж буй хүүхдүүдийн хувьд бэлгийн бойжилт, гэр бүл, сургуулийн орчны өөрчлөлт нь өсөлт дэвшлийг авчрахаас гадна шинэ эрсдлийг дагуулдаг. Ялангуяа

[1] https://www.legalinfo.mn/law/details/11709 Хүүхдийн эрхийн тухай хууль
[2] https://www.legalinfo.mn/law/details/1276 Хүүхдийн эрхийн конвенц
[3] https://mlsp.gov.mn/op/more/id/41
[4] БШУСайдын 2022 оны 11 сарын 9-ны өдрийн А/453 тушаалаар батлагдсан.
[5] БШУСайдын 2022 оны 12 сарын 20-ны өдрийн А/545 дугаар тушаалаар батлагдсан
[6] Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа-2023, ХНХЯ, БШУЯ, ЭМЯ, ДЭМБ, ЮНИСЕФ, 2024 он.

энэ үед эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хайр халамж бага, хараа хяналт сул, түр болон удаан хугацаагаар эцэг эхээсээ хол амьдрах нь хүүхдүүдэд учирч болох эрсдлийг нэмэгдүүлдэг. Судалгааны мэдээлэл цуглуулах үед ***хотын хүүхдүүдийн 62,9 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 42,4 хувь нь эцэг эхийн хамт амьдарч байгаа*** хэмээн хариулсан. Хөдөөгийн хүүхдийн 41,1 хувь нь бусад буюу эмээ, өвөө, хамаатан садан, таньдаг айлд эсхүл дотуур байранд амьдарч байна.

Хүүхэд хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэлийг зайлшгүй хэмээн 4 хүүхэд тутмын 1 нь хариулсан байгаа нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх соёл буйг илтгэнэ. ***Цахим дээрэлхэлтэд өртөх эрсдэл охид хөвгүүдээс 7,6 хувиар илүү байна. 2 хүүхэд тутмын 1 нь огт танихгүй хүнтэйгээ интернэт орчинд харилцаж байсан бөгөөд 26 хувь нь биечлэн уулзсан байна. Биечлэн уулзсан тохиолдол охид хөвгүүдээс 8.9 хувиар илүү байна***. Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь нэгээс олон буюу дунджаар нэг хүүхэд 3-4 фейсбүүк хаягтай байна. Тус судалгаанд оролцогч хүүхдүүд нийгмийн сүлжээний хэд хэдэн хаяг нээж ээж аавтайгаа, найзуудтайгаа гэх мэтээр өөр өөр зорилгоор олон хаяг ашиглаж байгааг дурдсан. Цахим орчны зөв зохистой хэрэглээний талаарх хүүхдүүдийн ойлголт дутмаг, болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах талаар ойлголт сул байгааг судалгаанд оролцогч талууд онцолж байлаа. Хүүхдүүд нийгмийн сүлжээ ашиглан, бие биеэ гутаан доромжлох, худал мэдээлэл тараах, өмссөн хувцас, ар гэрийн нөхцөл байдлаар нь ялгаварлах, гадуурхах явдал түгээмэл байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн дээрх судалгаанд оролцсон хүүхдийн 50 хувь нь цахим дарамтад өртөж байсан бөгөөд тэдний ердөө 15 хувь нь энэ талаар эцэг эх, асран хамгаалагчдаа хэлсэн байна.[7] Нийт хүүхдийн 0.7 хувь нь сүүлийн 7 хоногт ганцаараа амьдарч байсан хэмээн хариулжээ.

Хүүхдийн сангийн судалгаанд, ЕБС-ийн багш нар хүүхдийг ар гэрийн нөхцөл байдал, гадаад байдлаар нь ялгаварлан гадуурхаж, бусад сурагчдын өмнө загнах, үг хэлээр доромжлох явдал түгээмэл гардаг. Сурагчид хүүхдийг ялгаварлан гадуурхдаг багш нарын талаар хаана, хэнд мэдээлж, хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй гэжээ. Багш нь хүүхдийг ялгаварлан гадуурхсанаас болж ангийн хүүхдүүд багшийг даган тухайн хүүхдийг нэмж дээрэлхэх үзэгдэл байдаг байна. Сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дарамтаас болж сургуулиас гарч, Насан туршийн боловсролын төвд суралцах хүсэлтэй хүүхдүүд ирдэг[8].

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2017 оны хүний эрхийн нөхцөл байдлын ээлжит илтгэлээр МУ-ын хүүхдийн эрхийн нөхцөл байдлын дэлгэрэнгүй судалгааг хийсэн байдаг. МУ-ын нийгэмд хүн амын бүлгүүдийн ялгаа гүнзгийрч, тэгш бус байдал ихсэж, тэр дундаа маргинал[9] бүлгийн хүүхдүүдэд хүнд сорилт бэрхшээлүүд тулгарч байна. Тэгш бус байдалд ядуурал, нас, хүйс, үндэс угсаа, нийгмийн гарал байдал, боловсролын түвшин хөгжлийн бэрхшээл болон оршин суугаа газарзүйн байршил зэрэг олон хүчин зүйл шууд, шууд бусаар нөлөөлж байна хэмээжээ. Хүүхдийн эрхийн хамгийн нийтлэг

[7] Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх судалгааны тайлан 2021 он

[8] Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгаа 2021 он

[9] Маргинал бүлэг- Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд гадуурхагдаж, боловсролын бодлого, төсөвлөлтийн хийдлээс сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг.

зөрчил нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл[10], үл хайхрах явдал байна. Асуулгад оролцсон нийт хүүхдийн 82.8 хувь нь ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртөж байсан [11], тэдний 62 хувь нь үг хэлээр доромжлох, 50.2 хувь нь чимхэх, 43.5 хувь нь цохиж зодох зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байна. Дүнг нэгтгэвэл, 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн ба давтамжийн хувьд бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртдөг ба энэ нь гэр бүл, сургуулийн орчинд хамгийн их гардаг байна. Сургууль дээрх дарамт хүчирхийлэл нь багш болон бусад сурагчдын зүгээс дээрэлхэх, хүчирхийлэх үйлдэл юм. Сургуулийн орчинд гарч буй хүчирхийлэлд хариу арга хэмжээ авахгүй байгаа нь ийнхүү хүчирхийлэл бүхий л орчинд газар авч байгаагийн гол шалтгаан болж байна.

ПИЗА олон улсын үнэлгээгээр 2023 оныг 2017 онтой харьцуулахад дээрэлхэлтийн хохирогч болсон хүүхдүүдийн эзлэх хувь 1 хувиар буурсан. Энэ нь онцын зөрүүгүй хэдий ч хэрэг мэдээллэх, шийдвэрлэх явдал эрс нэмэгдсэн байна. Мөн 15 настай монгол сурагчдын 9.7 хувь нь байнга дээрэлхдэг, 21.3 хувь нь ямар нэг төрлийн дээрэлхэлтэд өртсөн гэж мэдэгдсэн нь 2017 онтой харьцуулахад 16.1 пунктээр буурсан байна.

Монгол улсын хувьд боловсролын салбарт малчдын хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд хамгийн чухал зүйл бол дотуур байрны үйлчилгээний чанар, хүртээмж юм.

2021 оны 8 сарын 25-нд дунд сургуулийн танхимын дүрэм, хэм хэмжээг тогтоосон тогтоол батлагдсанаас хойш 1921-1940 оны хооронд ЕБС-ийн тогтолцоо үүсэх явцад малчдын хүүхдийн сурах нөхцөл бий болгож дотуур байрны асуудлыг шийдэх болсон байна. Сурагчид хичээлийн жилд 9 сар буюу жилийн 224-245 хоногт эцэг эх, асран хамгаалагчдаасаа хол дотуур байрны багш, тогооч, ажилтны асрамжинд сурч хөгждөг. Дотуур байранд амьдарч байгаа нийт хүүхдүүдийн 82 хувь нь малчин өрхийн хүүхдүүд байна[12]. Тиймээс БШУЯ-аас 2022 онд ЕБС, дотуур байрны хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам[13]-ыг баталсан нь сайшаалтай. Сургууль хүүхдэд боловсрол эзэмшүүлэхээс гадна эрх нь зөрчигдөхөөс хамгаалах үүргийг мөн хүлээдэг[14]. Гэтэл хүний эрхийн болон хүүхдийн эрхийн нөхцөл байдлын судалгаануудаас үзэхэд, сурагчид сургууль, дотуур байрандаа үе тэнгийн дээрэлхэлтэд өртөх, ялгаварлан гадуурхагдах, хүчирхийлэл, гэмт хэрэгт холбогдох эрсдэлтэй байгаа нь хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулахгүй байна.

**Сургуулийн орчин, дотуур байр дахь хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үнэлгээний аргачлал** (цаашдаа Үнэлгээний аргачлал гэх) нь сургуулийн орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, бие махбодын шийтгэл, хорт зуршилд өртөх зэрэг эрсдэлт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилготой. Хүүхэд

[10] Хүүхдийн эсрэг хүчирхийлэл- Санаатай эсвэл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл, болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ. (Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4-р зүйл, 4.1.8 дахь хэсэг)

[11] МУ дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх 16 дахь илтгэл, ХЭҮК 2017 он, 13 дахь тал

[12] https://mecss.gov.mn/news/1259/

[13] БШУСайдын 2022 оны 11 сарын 09-ний өдрийн А/453 дугаар тушаалаар батлагдсан

[14] Боловсролын Ерөнхий хууль, СӨБ, Ерөнхий боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)

хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйл "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал"-д зааснаар,

- 23.1.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн шашны сургууль **хүүхэд хамгааллын бодлого**, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.
- 23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

хэмээн хуульчилж, авах арга хэмжээг нарийвчлан зааж өгсөн байна. Энэ хүрээнд ЕБС-иуд хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх үнэлгээ, түүнд үндэслэсэн хичээлийн жилийн туршид хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

Энэхүү үнэлгээний аргачлал нь 2021 оноос хойш сургууль, дотуур байрны аюулгүй байдлыг төрөөс анхаарч боловсролын салбарт баталсан дүрэм журам, хууль эрхзүйн актуудад нийцсэн болно. Үүнд, ЕБС, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам[15], СӨБ, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм[16] зэргээс харагдана. Үнэлгээний аргачлал нь эдгээр баримт бичгүүдийг голлон ашигласан.

Үнэлгээний аргачлалыг сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан “Үнэлгээний баг” хийх бөгөөд үнэлгээнээс гарсан үр дүнгийн мөрөөр сургууль, дотуур байранд авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж шинэ хичээлийн жилээс хэрэгжүүлэн ажиллах юм.

**Ач холбогдол.** Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйл Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалалд заасан сургалтын орчны нөхцөл байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үнэлгээний аргачлал нь сургуулийн орчинд хүүхдийг хүчирхийлэл, үл хайхралт, дарамт, дээрэлхэлт, эрсдэлт нөхцөл, гэмт хэрэг, зөрчил, бие махбодын шийтгэл, хорт зуршилд өртөхгүй байх зэрэг хүүхдийн эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хүрээнд хийгдэнэ.




[15] БШУСайдын 2022 оны 11 сарын 9-ны өдрийн А/453 тушаалаар батлагдсан
[16] БШУСайдын 2022 оны 12 сарын 20-ны өдрийн А/545 дугаар тушаалаар батлагдсан.

**Засаглалын орчин** нь сургуулийн удирдлагын зүгээс шийдвэр гаргахад оролцогч талууд болох сургуулийн хамт олон (сурагч, багш, ажилтан, эцэг эх, сурагч)-ыг оролцуулж санал бодлыг тусгадаг, бүтээлчээр хамтран ажилладаг үйл явц. Уг үйл явцад сургуулийн аливаа бодлого, дүрэм, журмыг тухайлбал, сургуулийн дүрэм, журам боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд талууд оролцдог, үнэлгээ, хяналт хийж сайжруулахад санал бодлоо тусгах чухал.
**Нийгэм-сэтгэл зүйн орчин** гэдэгт сургуулийн орчинд буй бүхий л харилцаа (сурагч-багш, багш-эцэг эх, эцэг эх-хүүхэд, багш-багш, удирдлага-багш, ажилтан гэх мэт) эерэг таатай уур амьсгалтай, аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлгүй байхыг ойлгоно.
**Материаллаг орчин** нь сургууль, дотуур байрны гадна, дотор орчин хүүхдэд аливаа эрсдэлт нөхцөл байдал үүсгээгүй, гэрээс сургууль хүртэлх зам, сургуулиас гэр хүртэлх зам, тээврийн аюулгүй байдал, гудамж талбайн гэрэлтүүлэг, гуу жалга, дэлгүүр, гарц зэргийг хамруулан ойлгож байна.

**Олон талт Үнэлгээний баг гэж юу вэ?**
Боловсрол дахь хүүхэд хамгааллын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын баг, түүнээс гадна эцэг эхийн зөвлөл, Сурагчдын өөрийн удирдлагын байгуулал, иргэний нийгмийн байгууллага, сургуулийн ажилтан, албан хаагчдын төлөөллөөс бүрдсэн сайн дурын баг байна.
**Давуу тал:** Сурагч, эцэг эх, багш, ажилтан, сургуулийн удирдлага зэрэг олон талт төлөөлөл хүүхдийн эрхэд суурилсан хандлагаар ойлголтоо нэгтгэж, ололт амжилт, шийдвэрлэх асуудлуудаа өөр өөрийн өнцгөөс харж сургуулийнхаа хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажлыг хамтран хийх, цаашлаад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх боломж юм.
**Сул тал:** Олон талын төлөөллийн оролцоог хангах нь давуу талтайн зэрэгцээ тэдгээр хүмүүсийн цаг баримталж нэгдэн ажиллах тал дээр учир дуталдалтай байх эрсдэлтэй. Мөн эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаарахгүй бол ажилгүй, малчин эцэг эх, сургуулийн үйлчилгээний ажилтан, хүүхдийн дуу хоолойг орхигдуулах хандлага байдаг учир анхаарна уу.

ЕБС, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын 3.3-т заасан Хүүхдийг хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ЕБС, дотуур байрны орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэлийн 4.3-т заасан сургууль дахь үе тэнгийхний дарамт, ялгаварлан гадуурхалтын нөхцөл байдлыг тогтмол үнэлэх, “эрсдэлтэй газрууд”-д насанд хүрэгчийн хараа хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэг хэсэг юм. Уг үнэлгээний аргачлалыг ЕБС-иуд, дотуур байранд хийснээр сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх эрсдэлт хүчин зүйлийг урьдчилан харж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авснаар хүүхдийн эрхийн зөрчил багасаж, хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхээ эдлэх боломж бүрдэнэ.

*Үнэлгээг хичээлийн жилийн эхний сард, эсвэл хичээлийн жилийн төгсгөлд хийж үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажлын төлөвлөгөөг гарган, шаардлагатай бол сургуулийн төсөвт суулгаж, сургуулийн захиралын манлайлал дор сургуулийн хамт олон, эцэг эх, сургуулийн зөвлөлд танилцуулна. Улмаар*

*төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллахад сургуулийн хамт олны оролцоог ханган ажиллана.*

**Нэр томьёоны тайлбар**

**Аюулгүй орчин:** Нийгэм-улс төрийн шинжтэй ойлголтыг илэрхийлэх бөгөөд үүний наад захын шаардлага нь нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх, хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодын аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрдүүлэхэд оршино.

(Хүний эрхийн товч тайлбар, 2015)

**Бэлгийн дарамт**: Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээр үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн

бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг;

(Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 4.1.7)

**Бэлгийн цөөнх (ЛГБТИК+):** Лесбиан, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, куийр болон бусад гэсэн үгсийн товчлол. Энэ нь бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог.

**Бэлгийн чиг баримжаа**: Сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно  харилцаа үүсгэх хүн бүрийн гүн гүнзгий мөн чанар юм.

**Хүйсийн баримтжаа:** Хүн бүр өөрийн хүйс, биеэ мэдрэх гүн гүнзгий, төрөлхийн мэдрэмж юм.

**Жендэрт суурилсан хүчирхийлэл:** Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

(Жендэрийн тэгш байдлыг хангах тухай. МУ-ын хууль. 4.1.8)

**Орчин**: Байгалиас түүнчлэн хүний гараар бүтсэн тухайн хүний болон хүний олонлогийн эргэн тойрныг хамруулсан ойлголт юм.

(Хүний эрхийн товч тайлбар, 2015)

**Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээтэй) хүүхэд:** “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг; (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 4.1.1) Өвчин, бэртэл гэмтлийн үр дагавар буюу *гаж хөгжл*ийн улмаас үйл ажиллагаа нь хязгаарлагдаж, нийгмийн зайлшгүй хамгаалалт шаардлагатай болсон организмын чиг үүрэг гүнзгий хямралд орж эрүүл мэнд нь сарнисан хүүхдийг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь нийгмийн сөрөг үнэлэмжийн улмаас нийгмээс тусгаарлагдаж үл болно.

**Хүүхэд**: Хэрэв тухайн хүүхдэд үйлчлэх хуулийн дагуу түүнээс эрт насанд хүрсэн гэж үзэхгүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. Хүүхэд нь бие бялдрын болон оюун санааны хувьд төгс боловсроогүй байдаг учраас тусгай асрамж, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт, онцгой хайр халамж шаардах эрхтэй.

(Хүүхдийн эрхийн тухай конвенц 1-р заалт)

**Хүүхдийн эрх:** Хүүхдийн эдлэх ёстой эрх, эрх чөлөө, төрөөс болон эцэг эхээс нь үзүүлэх ёстой халамж, үйлчилгээний цогцыг хүүхдийн эрх гэнэ.

(Хүний эрхийн товч тайлбар, 2015)

**Хүүхдийн сайн сайхан байдал:** Хүүхдийн бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, боловсрол, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага хангагдсан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг;

(Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга, 2024)

**"хүүхэд хамгаалал"** гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;

**"хүүхдийн эсрэг хүчирхийлэл"** /цаашид "хүчирхийлэл" гэх/ гэж хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулах, бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг;

**Урьдчилан сэргийлэх:** Урьдчилан сэргийлэх гэдэгт хүүхдийг хууль зөрчихөөс хамгаалах таатай орчныг идэвхтэйгээр бүрдүүлэхийг ойлгоно. Энэхүү орчин нь хүүхэд боломжийн хэмжээгээр амьдарч аж төрөх баталгааг бий болгож, түүний хөгжих, боловсрохыг бүх талаар дэмжиж, гэмт хэрэгт татагдан орохоос аль болох хөндийрүүлэхэд чиглэнэ.

(Хүүхдийн эрхийн нэр томьёоны тайлбар

**Үе тэнгийн дээрэлхэлт:** Нэг буюу хэд хэдэн хүүхэд өөр нэг буюу хэд хэдэн хүүхдийг бие махбод, сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой түрэмгий зан үйлээ санаатайгаар, удаа дараа биеэр, амаар болон цахим орчинд үйлдэхийг;

(Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга, 2024)

**Үндэстний цөөнх:** Тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьс өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ. Үндэстний цөөнх нь өөрийн соёл иргэншлээ хадгалж үлдэх, өөрийн шашныг шүтэх, төрөлх хэлээрээ ярих эрхээр хангагдах ёстой.

(Хүний эрхийн нэр томьёоны товч тайлбар, 1996)

**Үл хайхрах:** хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үүрэг хүлээсэн бусад этгээд хүүхдийн аюулгүй байдал, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсрол, хөгжлийн хэрэгцээг гачигдуулсан, асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсныг;

(Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга, 2024)

**Эгэх хариуцлага/Хариуцан тайлагнах:** Хариуцан тайлагнах нь хэд хэдэн утгыг илтгэдэг ёс зүйн үзэл баримтлал хариуцлага, хариулах, дагаж мөрдөх, гэм зэмээ хүлээх, үүрэг хүлээх болон тайлагнахтай холбоотой бусад нэр томьёотой ойролцоо утгатай. Олон хэлэнд энэ нэр томьёо оносон орчуулгагүй байдаг тул түүнийг эхнээс нь задалж ойлгох нь тустай. Хариуцан тайлагнах ажиллагаа: 1) хариуцлага; 2) үр дагавар гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Нэгдүгээрт, “хариуцлага” гэдэг нь төрийн албан хаагчид эрх мэдлийг яаж хэрэгжүүлсэн, хөрөнгө мөнгийг хэрхэн зарцуулсан, түүгээр ямар үр дүнд хүрсэн зэрэг асуултад тогтмол хариулж байх; хоёрдугаарт, “үр дагавар” урьдаас тодорхой, утга учиртай (энэ нь заавал шийтгэл хүлээлгэх, хөрөнгө мөнгө, хувь хүнтэй холбоотой байх гэсэн үг биш) байх шаардлагын тухай юм. Гуравдугаарт, засгийн газрын байгууллага эрх мэдэл, хөрөнгө мөнгийг хэрхэн ашигласан, улмаар хүрсэн үр дүнгийн талаар нийтэд тайлагнах шаардлагатай байдаг учраас захиргааны хариуцан тайлагнах дотоод тогтолцоо нь үйлчилгээг хэрэглэгчид, иргэдийн санал хүсэлтийг тусгасан хариуцан тайлагнах гадаад тогтолцоотой хамтран үйлчилснээр бүрэн хэрэгжинэ.

(Шиаво & Сундарам, 2000. Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг Ц.Даваадулам, 2010)
(Хүний эрхийн товч тайлбар, 2015)

**Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд** гэж дараах хүүхдийг Хүүхэд хамгааллын хуульд (4.1.4) зааснаар,

4.1.4.а.амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд;
4.1.4.б.хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд;
4.1.4.в.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд;
4.1.4.г.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдалд байгаа хүүхэд гэж ойлгоно.

**Ялгаварлан гадуурхалт:** "Ялгаварлан гадуурхалт гэдэгт хүний арьс, өнгө, хүйс, хэл,шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, гарал үүсэл, хөрөнгө чинээ, төрсөн газар, нийгмийн байдал, бусад байдалд нь үндэслэн ямарваа нэгэн зайлуулах, гадуурхах, хориглох эсвэл дорд болон илүүд үзэх зэрэг үйлдлүүдийг ойлгох бөгөөд эдгээр нь хүн бүрт тэгш оноогдсон хүний эрх, эрх чөлөөг үгүйсгэх буюу устгах зорилго агуулсан байна" гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороо тодорхойлсон байна. Ялгаварлан гадуурхалт нь эрх тэгш байдлыг үгүйсгэж, хүний эрх зөрчигдөхөд хүргэдэг.

**Үнэлгээ хийхэд баримтлах зарчим**

**1. Хүний эрхийг дээдлэх зарчмыг үнэлгээнд баримтлах**

МУ-ын Үндсэн хууль, Олон улсын гэрээ конвенцид тусгагдсан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтууд болон бусад хууль тогтоомж, судалгааны ёс зүйн дүрэмд тусгасан хүний эрхийг дээдлэн хүндэтгэх зарчмыг судалгаа хийх явцдаа баримтлан ажиллах. Үүнд: нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, нийгмийн байдлаар ялгаварлахгүй байх, хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэх

Хүүхдийн эрхийг хамгаалахад дараах зарчмыг баримтална:

- Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих,
- Хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх оролцоог хангах,
- Хүүхэд хамгаалал нь тогтолцоонд суурилсан, гэр бүл төвтэй, олон талт, цогц, мэргэшсэн, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх,
- хүүхдийн нөхцөл байдал, ялгаатай онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх,

**2. Үнэлгээнд оролцогчдод хувийн үзэл бодлоо тулгахаас зайлсхийх**

Ярилцах явцдаа хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дээдлэхийн зэрэгцээ үнэлгээний асуулттай холбоотой үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөхөд анхаарна.

Оролцогчдыг албадлагын бус сайн дурын үндсэн дээр үнэлгээний оролцогчоор оролцуулна.

**3. Мэдээллийн нууцлалыг чанд хадгалах, хамгаалах**

Сэтгэлзүйч, нийгмийн ажилтан нь нийгэм-сэтгэлзүйн орчны үнэлгээнд оролцогчдын хувийн мэдээллийг задруулахгүй байж мэргэжлийн ёс зүйг баримтлан ажиллах үүрэгтэй.

**4. Шаардлагатай мэдээллийг баталгаажуулах, баримтжуулах**

Хэрэв шаардлагатай бол үнэлгээний багийн гишүүд тухайн мэдээллийг баталгаажуулах ба баримтжуулалтын аливаа төрлийг ашиглахдаа үнэлгээнд оролцогчоос (сурагч, багш, эцэг эх, ажилтан гэх мэт) зөвшөөрөл авна. Мэдээллийг баталгаажуулах дараах төрлүүд байж болно.

- Цаасан дээр тэмдэглэл хөтлөх
- Компьютерт бичиж тэмдэглэх
- Дуу хураагуур ашиглах бол зайлшгүй зөвшөөрөл авна. Зөвшөөрлийг бичгээр гарын үсэг зуруулж авна.

**5. Үнэлгээний ёс зүйн зарчмыг мөрдөх**

Үнэлгээний багийн гишүүд тухайн үнэлгээг /Олон улсын ёс зүйн код/ ёс зүйн дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэхэд анхаарна. Энэхүү үнэлгээ нь эмзэг бүлгийн хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгарч буй саад бэрхшээлийн нөхцөл байдлыг тодорхойлж, үндэсний түвшинд ашиглагдах мэдээллийн эх сурвалж бий болгох тул, энэ талаар тайлбарлан таниулах хэрэгтэй.

**6. Оролцогчдыг сонгохдоо анхаарах**

Үнэлгээнд оролцох хүүхдийг санамсаргүй түүврийн аргаар сонгох.

**7. Үнэлгээ хийх орчин бүрдүүлэх**

Үнэлгээнд оролцогчдод чимээгүй, тухтай, тайван орчинд ярилцах, бодох, эргэцүүлэх боломжийг олгох бөгөөд ямар нэгэн тулгасан шахалт, дарамт учруулсан байдлаар биш нээлттэй ярилцана.

**Нэгдүгээр хэсэг: Үнэлгээ хийх бэлтгэл**

1. **Сургуулийн удирдлага, хамт олонд мэдээлэл өгөх**

Сургуулийн орчин, дотуур байр дахь хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийх талаарх мэдээллийг сургуулийн удирдлагын баг болон хамт олонд (багш, ажилтан, эцэг эх, сурагчдад) уулзалт, хурлаар болон бусад хэлбэрээр өгнө. Мэдээлэлд үнэлгээ хийх зорилго, үндэслэл, үнэлгээний баг байгуулах, ач холбогдлын талаар ойлголт өгнө.

2. **Үнэлгээний баг байгуулах**

Сургуулийн захирал хүүхэд хамгааллын багийн ахлагчийн хувиар үнэлгээний багийг сайн дурын үндсэн дээр *сургуулийн удирдлага, багш, ажилчдын хурал, СӨУБ-ын хурал, сургуулийн эцэг эхийн байгууллагын уулзалт, хурлаас* тус тус хэлэлцэн, сонгосон гишүүдэд хамтран ажиллах хүсэлт тавина. Зөвшөөрсөн гишүүдийг бүртгэлийн хуудсанд бүртгэж баталгаажуулна.

Бүртгэлийн хуудасны загвар:

| **№** | **Овог нэр** | **Аль бүлгийн төлөөлөл (эцэг эх, багш, сурагч гм)** | **Холбогдох дугаар** | **Цахим хаяг/Фейсбүүк** | **Хүйс** |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Үнэлгээний баг 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, хүйсийн тэнцвэрийг хангасан байвал зохино. Үүнд:

1. Сургуулийн удирдлагын багийн төлөөлөл (нийгмийн ажилтан) - 1
2. Багш -1
3. Ажилтан (Дотуур байртай бол дотуур байрны багш) - 1
4. Хүүхэд (дунд, ахлах ангийн төлөөлөл) – 2
5. Эцэг эх (төрийн албан хаагч, малчин, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн төлөөллийг хангахыг эрмэлзэх, бага, дунд, ахлах ангийн төлөөлөл) – 2
6. Иргэний нийгмийн төлөөлөл - 1 хүн

3. **Ойлголт нэгтгэх семинар зохион байгуулах**

Дээрх үнэлгээний багийн гишүүддээ ойлголт нэгтгэх хагас өдрийн семинар зохион байгуулна.

**Семинарын зорилго:** Сургуулийн орчин (дотуур байр) дахь хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлыг үнэлэх багийн гишүүд ойлголтоо нэгтгэж, үнэлгээний аргачлалд суралцах боломж олгох.

Энэ семинараар багийн гишүүдэд үнэлгээ хийх үндэслэл, зорилго, баримтлах зарчим, ач холбогдлын талаар ойлголт өгнө. Мөн үнэлгээг үр дүнтэй хийх ур чадварт суралцана.

**Бэлтгэх материал:**

- Бүртгэлийн хуудас
- Гарын авлага (үнэлгээний аргачлал)
- Төлөвлөгөө хийх хүснэгт
- Зураглал хийх заавар
- **Засаглалын орчныг үнэлэх асуулга**
- **Нийгэм-сэтгэл зүйн асуулга**
- **Материаллаг орчны асуулга**
- Самбарын цаас
- Өнгийн маркер
- Зөөврийн компьютер, дэлгэц
- Баримтжуулалт хийх хэрэгсэл (зургийн аппарат, дуу хураагч гэх мэт)

**Семинар зохион байгуулахад анхаарах зүйлс:**

- Семинарыг багийн гишүүдийн цаг зав, ажлын боломжинд тааруулан цаг товлож зохион байгуулна.
- Багийн гишүүдтэй нэг бүрчлэн холбогдож, семинарын талаар мэдээлэл өгч товлосон хугацаанд семинарт оролцох боломжтой эсэхийг лавлах
- Семинар хийх хугацаа, байршил тодорхой болсон үед хэзээ, хаана, хэдэн цагт хэр хугацаатай үргэлжлэх талаар гишүүдэд мэдээллээ өгнө.
- Семинар хийх анги танхимыг сургуулийн удирдлагуудтай урьдчилан ярилцаж бэлдсэн байна.
- Семинарын үеэр хэрэглэх зүйлсийг жагсаан бичиж, бэлтгэнэ. Үүнд: Зөөврийн компьютер, дэлгэц, баримтжуулах хэрэгсэл, самбарын цаас, маркер, бүртгэлийн хуудас, тараах материал гэх мэт

Семинарыг загвар хөтөлбөрийн дагуу зохион байгуулж болно. (Хугацааг өөрсдийн боломжид тааруулан өөрчилж хийнэ)

| **Хугацаа** | **Агуулга** |
|---|---|
| | Бүртгэл |
| | Нээлт, танилцах цаг |
| | Багаар ажиллах: “**Миний мөрөөдлийн сургууль**”<br>Уг дасгалаар сургууль тус бүрийн оролцогчид багаараа ярилцан тус самбарын цаасан дээр мөрөөдлийн сургуулийнхаа сураглалыг гаргана. Түүнийгээ өөрийнхөө сургуультайгаа жишиж ярилцана. |
| | Танилцуулга: Үнэлгээ хийх үндэслэл<br>Дасгал: Ёс зүйн зарчим |
| | Танилцуулга: Сургууль, дотуур байрын орчин дахь хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээний аргачлал (бүтэц, агуулга, үнэлгээний 3 орчинд (Засаглалын, Нийгэм-сэтгэлзүйн, Материаллаг) хэн хэн, юу хийхийг тодорхой оруулах) |
| | Цайны завсарлага |

| | |
|---|---|
| | Багаар ажиллах: Үнэлгээ хийх төлөвлөгөө, төсөв боловсруулах (сургууль сургуулиараа) |
| | Дадлага ажил:<br><br>Чиглүүлэгч Нийгмийн ажилтан<br>· Зураглал - Сурагчид<br>· Засаглал - багш, ажилчид<br>· Нийгэм - сэтгэл зүй – Сэтгэлзүйч,<br>· Материаллаг орчин – эцэг эх, асран хамгаалагч |
| | Танилцуулга: Үнэлгээг нэгтгэх, зөвлөмж боловсруулах |
| | Дүгнэлт, хаалт |

Семинарын төгсгөл дүгнэлт хэсэгт багаараа дараах шалгах хуудсыг бөглөж, ажил эхлэхэд бэлэн эсэхээ шалгаарай.

**Шалгах хуудас**

- Багийн гишүүдийн овог нэр, холбогдох утас, цахим хаяг, эрхэлж буй ажил, аль бүлгийн төлөөлөл болох талаар холбогдох мэдээллээ солилцсон уу?
- Уулзалт бүрт бүртгэл, тэмдэглэл хөтөлж, баримтжуулах бэлтгэлтэй байгаа юу?
- Гишүүн бүр үнэлгээний гарын авлага, бусад шаардлагатай материалуудтай танилцсан уу?
- Гишүүн бүр өөрийн хариуцсан ажлын хугацаа, хуваариа сайн мэдэж авсан уу?
- Ажиглалт, асуулга, ярилцлагын хуудсыг бүлэг тус бүрийн тооны дагуу хэвлэж бэлдсэн үү?
- Асуулга, ярилцлагаа авахдаа бэлдэж, сайн танилцсан уу?
- Үйл ажиллагааг баримтжуулах, тэмдэглэл хөтлөх, дүнг нэгтгэх зэрэг асуудлуудаа урьдчилан ярилцаж, шийдвэрлэсэн үү?

Жич: Үнэлгээ хийх сургуулийн онцлог, нөхцөл байдлаас хамааран асуулгын хуудас, бусад материалыг Казах, Тува болон бусад хэлээр орчуулах шаардлагатай эсэх, мөн харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж томруулж хэвлэх болон брайль үсэг рүү хөрвүүлэх, дохионы хэлний хэлмэрч орчуулагч шаардлагатай эсэх асуудлуудыг урьдчилан зөвлөлдөж, шийдвэрлэнэ.

### 4. Үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулах

Багийн гишүүд ойлголт нэгтгэх семинарын үед үнэлгээ хийх төлөвлөгөөгөө хамтран боловсруулна. Үнэлгээг хийхдээ баг болж ажиллана. Үүнд:

- Материаллаг орчны баг:
  Зургаар үнэлэх -
  Ажиглалт: Эцэг эх, дунд ангийн сурагч,
- Нийгэм-сэтгэл зүйн орчны баг: сэтгэл зүйч, нийгмийн ажилтан
- Засаглалын орчны баг: Багш, эцэг эх, сургуулийн ажилтан, сурагч

**Төлөвлөгөө боловсруулахдаа дараах загварыг ашиглаж болно.**

| № | Хийх ажил | Хугацаа | Багаас хариуцах гишүүн |
|---|---|---|---|
| **Бэлтгэл** | | | |
| 1. | Сургуулийн удирдлага хамт олонд мэдээлэх | | |
| 2. | Үнэлгээний багийн гишүүдийг сонгох | | |
| 3. | Ойлголт нэгтгэх семинар | | |
| **Материаллаг орчны баг** | | | |
| 1. | Сургуульд ирж очих замын зураглал гаргах | | |
| 2. | Сургууль, дотуур байрны ажиглалтын хуудас хэвлэх, ажиглалт хийх | | |
| 3. | Ажиглалтын дүнг нэгтгэх | | |
| **Нийгэм-сэтгэл зүйн орчны баг** | | | |
| 1. | Сурагчтай ганцаарчилсан ярилцлага хийх | | |
| 2. | Сургуулийн багш, ажилтантай ганцаарчилсан ярилцлага хийх | | |
| 3. | Асран хамгаалагч, гэр бүлийн гишүүнтэй ганцаарчилсан ярилцлага хийх | | |
| 4. | Дотуур байранд нэмэлтээр үнэлгээ хийх | | |
| 5. | Сурагчидтай бүлгийн ярилцлага хийх | | |
| 6. | Ярилцлагын дүнг нэгтгэх | | |
| **Засаглалын орчны баг** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг үнэлэх хуудас | | |
| 2. | ЕБС, дотуур байрын орчинд суралцагчийг үе тэнгийхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийн хэрэгжилтийг үнэлэх хуудас | | |
| **Дүнг нэгтгэх** | | | |
| 1. | Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, зөвлөмж боловсруулах уулзалт зохион байгуулах | | |
| 2. | Сургуулийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх, ирэх хичээлийн жилийн хичээлээс гадуурх ажлын төлөвлөгөөнд тусгах санал боловсруулж, батлах | | |

**Хоёрдугаар хэсэг: Үнэлгээ хийх**

## 1. Материаллаг орчны үнэлгээ хийх



***а.* Сургуулийн орчныг зургаар үнэлэх**
**Бэлтгэл:** Самбарын цаас, шугам, өнгийн харандаа, баллуур, балын харандаа, маркер, зургийн аппарат, дуу хураагуур (шаардлагатай гэж үзвэл)

Сургуулийнхаа план (ариун цэврийн өрөө, шатны хонгил, булан, камер зэрэг бүгдийг зурна) зургийг самбарын цаас, өнгийн цаас, харандаа ашиглан зурж бэлтгэнэ.

**Үнэлгээнд оролцогчид:**
• Бага ангийн сурагч 2: 1 км-ээс хол гэрээсээ алхаж ирдэг эрэгтэй, эмэгтэй
• Дунд ангийн сурагч 2: Автобусаар болон явган ирдэг эрэгтэй, эмэгтэй хүүхэд
• Ахлах ангийн сурагч 2: Автобусаар болон явган ирдэг эрэгтэй, эмэгтэй

**Хугацаа:** 30-40 минут

**Зааварчилгаа:**

1. Та нар өөрийнхөө “Сургуулийнхаа план зургийг хамтдаа бүтээцгээгээрэй. Зурахдаа сургуулийнхаа барилгын булан тохой бүр, ойр орчимд байдаг зам, жижиг дэлгүүр, явган хүний зам зэргийг сайтар бодоорой.
2. Та нар ямар замаар явж ирдэг, ирэх болон буцахад айдастай эсвэл тайван явдаг хэсэг юу байдаг, хэнтэй хамт сургуульдаа ирж, харьдаг, замд тохиолддог адал явдал, явган хүний зам ямар байдаг тааралддаг зүйлсээ сайтар бодоорой.
3. Зурахад заавал гоё сайхан зурах шаардлагагүй гэдгийг сануулна. Зурсан зурагт анги нэр бичих шаардлагагүй, нууцлалыг хадгалах болохыг тайлбарлаж өгнө.
4. Хүүхдүүд хоорондоо ярилцаад сургуулийнхаа план зургийг зурна.
5. Зурган дээрээ дараах зүйлсийг тэмдэглэнэ. Үүнд:
    a. Ариун цэврийн өрөөг тэмдэглээрэй. Цоож бүрэн бүтэн байна уу, түгжээтэй байна уу, хаалга нь аюулгүй хаагддаг уу, суултуур хагараагүй, бүрэн бүтэн байна уу, гадаах жорлон байдаг уу, байдаг бол сургуулиас хэр зайтай байдаг вэ, өвөл халтиргаатай байдаг уу, хаалга нь бүрэн бүтэн байна уу,
    b. Үе тэнгийн дээрэлхэлт хаана хаана гарч байна вэ? коридорт уу, ариун цэврийн өрөөнд үү, шатны хонгилд уу, харанхуй буланд уу,

завсарлагаанаар уу, хичээл тарахад уу, (гарын авлагsy 14-р талаас Халуун цэг, Оргил цагт юу ордогийг харна уу. )

6. Зургаа 20-25 минутанд багтаана зурна.
7. Зурж дууссаны дараа зургийг хүүхэд хүсвэл тайлбарлуулж бичиж, тэмдэглэж авна.



### *б. АЖИГЛАЛТ*

Материаллаг орчныг ажиглалт хийх аргаар үнэлнэ. Ажиглалт хийх тэмдэглэл хөтлөх хуудаст тэмдэглэл хөтөлтнө.

**Энэ багт оролцогчид:**
Эцэг эх, сурагч, нийгмийн ажилтан орж, сургууль болон дотуур байрны гадна, дотор орчинд аялал зохион байгуулж үнэлэх хуудасны дагуу тэмдэглэнэ.
Ажиглалт хийх өдөр, цагийг сургуулийн удирдлага, багш ажилтанд урьдчилан мэдэгдэж үнэлгээний баг ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Зааварчилгааг ойлголт нэгтгэх семинарын үед авсан байна. Ажиглалтын үнэлгээний хуудасны дагуу ярилцаж, тус бүртээ тэмдэглэл хийнэ.

**Бэлтгэл:** Ажиглалтын хуудсыг гишүүдийн тоогоор хэвлэсэн байна. Тэмдэглэх гаргацтай үзэг, бал, баримтжуулалт хийх зургийн аппарат хэрэгсэл.

**Хугацаа:** 60-90 минут

## 2. Нийгэм-сэтгэл зүйн орчны үнэлгээ хийх

Нийгэм-сэтгэл зүйн орчны үнэлгээг хийхдээ ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зохион байгуулна. Сургууль **сэтгэл зүйчтэй бол ганцаарчилсан ярилцлагыг** хийнэ. Сэтгэл зүйчгүй бол нийгмийн ажилтан, эсвэл хүүхдийн аюулгүй байдлыг хангаж нууцлалыг хадгалж чадах, итгэл даасан хүнийг томилж ярилцлага хийж болно.

**Ганцаарчилсан ярилцлагад** сурагч, багш, ажилтан, хүүхдийн асран хамгаалагч буюу гэр бүлийн гишүүн бүлэг тус бүртэй хийнэ.

- Сурагч- 6 (үүнээс **3 нь** *алслагдсан газраас сургууль руугаа явдаг, хөгжлийн бэрхшээлтэй, нийгэм эдийн засгийн статус доогуур өрхөд амьдардаг, үе тэнгийн дарамт дээрэлхэлтэд өртөж байсан, эсвэл эрсдэлтэй дунд, ахлах ангийн сурагч* )
- Багш –3
- Эцэг эх, асран хамгаалагч – 3 (бага, дунд,  ахлах анги)

**Сурагчдын бүлгийн ярилцлагад оролцогчид:** Өөрийн удирдлагын байгууллагын, дотуур байранд амьдардаг, амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, эрэгтэй, эмэгтэй гэх мэт төлөөллийг хангахад анхаарна. Үүнд:

- Дунд ангийн эрэгтэй, эмэгтэй 5 хүүхэд
- Ахлах ангийн эрэгтэй, эмэгтэй 5 хүүхэд

Бусад бүлгийн ярилцлагад ч төлөөллөө ханган зохион байгуулна.

**Ярилцлага хийх бэлтгэл:** Бүлэг тус бүрээс чиглүүлэх асуултыг хэвлэж бэлтгэнэ. Баримтжуулах хэрэгсэл: Зургийн аппарат, дуу хураагуур
**Хугацаа:** Ярилцлагад 40-60 минут зарцуулна.
**Зааварчилгаа:**

1. Ярилцлагын зорилгыг танилцуулж, зураг авах, дуу хураагуур ашиглах зөвшөөрөл авна. Үүнийг ярилцлагын үр дүнг нэгтгэхэд ашиглах бөгөөд өөр ямар нэгэн зорилгоор ашиглахгүй, тараахгүй болохыг хэлнэ. Оролцогчид зөвшөөрөхгүй бол зураг авахгүй байж болно.
2. Ярилцлагыг чиглүүлэх асуултын дагуу явуулах бөгөөд тодруулах зүйл гарвал нэмэлтээр асууж болно.
3. Хэт ерөнхий эсвэл дутуу хариултыг гүйцээн авахын тулд бататгасан, нэмэлт асуултууд асууж болно.

**Анхаарах зүйлс:**

- Ярилцлагыг зохион байгуулахаар хариуцсан гишүүд өөр өөрийн ярилцлагыг удирдана.
- Ярилцлага хийх, тэмдэглэл хөтлөх, баримтжуулалт хийх гишүүд нь хамт олны бус төлөөлөл байхад анхаараарай. (Жишээ нь багштай хийх ярилцлагыг эцэг эх, ажилтан, сурагчид хамтран явуулж болно).
- Гадна төрх, ярианы өнгөндөө анхаарлаа хандуулан, аль болох халуун дулаан, илэн далангүй, итгэл төрүүлэх уур амьсгал бүрдүүлэхэд анхаарна.

### 3. Засаглалын орчны үнэлгээ хийх

Энэ багт **багш, эцэг эх, сурагч, ажилтан, тбб-ын төлөөлөл** орно. Сургуулийн дүрэм журмууд, холбогдох бичиг баримтад дүн шинжилгээ хийнэ. Дүн шинжилгээ хийхдээ үнэлгээний хуудсыг ашиглана.

Сургуулийн нийгмийн ажилтан товлосон хугацаанд бичиг баримтыг бүрдүүлж, анги танхимаар хангах нөхцөлийг бүрдүүлж зохион байгуулна.
Үүнд шаардлагатай баримт бичгүүд:

1. Сургуулийн дүрэм
2. Сургуулийн дотоод журам
3. Сурагчдын дүрэм
4. Дотуур байрны журам, дэг
5. Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө
7. Багшийн ёс зүйн дүрэм
8. Ажилд авах журам

**Гуравдугаар хэсэг: Үнэлгээний дүнг нэгтгэх, зөвлөмж боловсруулах**

1. Үнэлгээг нэгтгэх уулзалтыг нийгмийн ажилтан зохион байгуулна.
2. Орчин тус бүрийн багийн үнэлгээний үр дүнг нэгтгэсэн тайлан бэлтгэж үнэлгээний нэгтгэл хийх уулзалтад танилцуулна.
3. Үнэлгээг нэгтгэх Excel файлыг танилцуулж хэвлэсэн хувийг хүн тус бүрт өгч үнэлгээ хийлгэнэ.
4. Багийн гишүүн бүрийн олонхийн сонголтыг Excel файлд оруулж дундаж оноог гаргана. Үндэслэл нотолгоонд суурилсан сонголтыг хийнэ.
5. Тухайн шалгуур бүрт сайжруулах, бататгах саналыг хүн тус бүрээс асууж самбарт бичнэ.
6. Саналын жагсаалтаас бүх оролцогчоос хамгийн түрүүнд шийдвэрлэх 3 үйл ажиллагаа сонгуулж нэгдсэн зөвлөмжийг хуснэгтэнд боловсруулна.
7. Зөвлөмжийг Сургуулийн удирдлагад хүлээлгэн өгнө. Үнэлгээний ерөнхий үр дүн, зөвлөмжийг мэдээллийн самбарт хадах, багш ажилчид, эцэг эхийн хурлаар танилцуулан сургуулийн төлөвлөгөөнд тусгуулна.

Алхмууд:



**Санал зөвлөмжийг нэгтгэх хүснэгт**

| Хүрээ | Шалгуур 1-ийн дагуу гарсан тулгамдсан 3 асуудал | Шалгуур 2-ын дагуу гарсан тулгамдсан 3 асуудал | Шалгуур 3-ын дагуу гарсан тулгамдсан 3 асуудал | Шийдвэрлэх санал зөвлөмж |
|---|---|---|---|---|
| ***Материаллаг орчин*** | 1.<br>2.<br>3. | 1.<br>2:<br>3. | 1.<br>2.<br>3. | |
| ***Нийгэм, сэтгэл зүйн орчин*** | 1.<br>2.<br>3. | 1.<br>2.<br>3. | 1.<br>2<br>3. | |
| ***Засаглалын орчин*** | 1.<br>2.<br>3. | 1.<br>2.<br>3. | 1.<br>2.<br>3. | |

Сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал зөвлөмжийг нийт оролцогчид боловсруулан сургуулийн удирдлага, эцэг эхийн зөвлөл, сурагчдад нээлттэй танилцуулна.
Энэхүү үнэлгээг жил бүр хэрэгжүүлэх нь хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоог сайжруулах хяналт үнэлгээний цогц хэрэглэгдэхүүн болж чадна.

Үнэлгээний баг 1 дүгээр үеийн үнэлгээний үр дүнг хүлээн авсны дараа нэгдсэн уулзалтаар дараах аргачлалаар үнэлгээг нэгтгэнэ.

**Үнэлгээ өгөх**

Тухайн орчныг үнэлэхдээ 1 дүгээр түвшин буюу эрсдэлтэй түвшнээс 4 дүгээр түвшин болох эрсдэлгүй түвшин хүртэл өмнөх бүлэг хүмүүсийн үнэлгээний тайлантай танилцсаны үндсэн дээр нотолгоо болгон оноог оролцогч бүр бие даан дүгнэж хүснэгтэд байгаа жагсаалт бүрээр тэмдэглэгээ хийж өгнө.
Эрсдэлгүй түвшин ч хамгийн сайн байж болох магадлалтай тул үүнээс ч илүү сайн жишээ, туршлага байж болох юм гэдгийг оролцогчид санаарай.

## 1. Сургуулийн орчин

| Шалгуур\ Түвшин | 1 - Эрсдэл ихтэй | 2 - Дунд эрсдэлтэй | 3- Бага эрсдэлтэй | 4 -Эрсдэлгүй |
|---|---|---|---|---|
| Шалгуур 1 – Сургуулийн дотоод орчин | 1. Сургууль доторх аюулгүйн гарцын тэмдэглэгээний самбар байхгүй, цуглах газар тодорхойгүй<br>2. Сургуулийн коридор харанхуй булан ихтэй, өндөр шаттай<br>3. Бие засах өрөөгүй, гар угаах угаалтуур байхгүй<br>4. Бүх хүүхдэд ширээ сандал хүрэлцээгүй, хуучирч эвдэрсэн, өргөс, хадаас ихтэй<br>5. Сургуулийн эмчид анхны тусламжийн хайрцаг байдаг ч эм хэрэгсэл хангалгүй<br>6. Сургуулийн автобусгүй<br>7. Сургуулийн цонх зарим газар хагарсан, эвдэрхий осолтой тавилга хэрэгсэл их<br>8. Сургуулийн коридор, анги дотор цахилгааны утас ил монтажтай, сул эвдэрсэн залгуур их | 1. Сургууль доторх аюулгүйн гарцын тэмдэглэгээний самбар хадсан, цуглах газар тодорхойгүй<br>2. Сургуулийн коридор гэрэлтүүлэгтэй, тэргэнцэртэй хүүхэд сурах боломцоогүй<br>3. Бие засах өрөөгүй ч гар угаах угаалтуур байрлуулсан<br>4. Бүх хүүхдэд ширээ сандал хүрэлцээтэй ч нэг загвартай өндөртэй, эвдэрч хуучирч байгаа<br>5. Сургуулийн эмчид анхны тусламжийн хайрцаг байдаг, тогтмол шинэчилдэг<br>6. Сургуулийн автобус байдаг ч ажилладаггүй<br>7. Сургуулийн цонхнууд хагарсан ч аюулгүй болгож | 1. Сургууль доторх аюулгүйн гарцын тэмдэглэгээний самбарыг хаана байдгийг хүн бүр мэддэг, аливаа аюул болсон тохиолдолд цуглах газар тодорхой<br>2. Сургуулийн коридор гэрэлтүүлэг сайтай, нэг давхраас дээш тэргэнцэртэй хүүхдийн анги хичээллэдэггүй<br>3. Сургууль дотроо бие засах өрөөтэй Суултуурын ус сайн ирдэг Бие засах өрөөнд гарын угаалтуууртай Гар угаалтуурын ус сайн гоождог<br>4. Бүх ширээ, сандал хурц ирмэггүй, цухуйсан хадаас зэрэг байгаа<br>5. Анги бүр анхны тусламжийн хайрцагтай<br>6. Сургуулийн автобус, машин үйлчилгээнд хамрагддаг, тогтсон цагтаа байнга явдаг<br>7. Сургуулийн цонхнууд хагараагүй бүрэн бүтэн хагараагүй, тавиур өлгүүр ханадн бэхлээгүй<br>8. Сургуулийн коридор, анги дотор гэмтсэн цахилгааны залгуур байхгүй ч хамгаалалтгүй | 1. Сургууль доторх аюулгүйн гарцыг хүүхэд бүрт тайлбарлаж, мэддэг болсон, аливаа аюул болсон тохиолдолд хаана цуглах, хэнд хандахаа хүүхэд бүр мэддэг<br>2. Коридор өргөн цэлгэр, нэг давхраас дээш тэргэнцрээр зорчих, харааны бэрхшээлтэй хүн саадгүйгээр шатаар зорчих боломжтой<br>3. Бие засах өрөө нас, хүйсээр тусдаа байгаа, хаалга түгжээтэй, гар угаах савантай, үргэлж цэвэр байдаг<br>4. Бүх ангийн ширээ, сандал хүүхдийн нас биед тохирсон бүрэн бүтэн<br>5. Анги бүр анхны тусламжийн хайрцагтай, хэрэглэх зааврыг хүүхэд багш мэддэг<br>6. Сургуулийн автобус, машин эвдрэлгүй, техникийн үзүүлэлтүүдээ бүрэн хангасан, жолооч ажиллах шалгуур хангасан, харгалзах багш явдаг тэргэнцэртэй хүүхдэд үйлчлэх нэмэлт тоног төхөөрөмжөөр хангагдсан<br>7. Сургуулийн цонхнууд хагараагүй бүрэн бүтэн, тавиур, өлгүүр зэргийг хананд бэхлэгдсэн<br>8. Сургуулийн коридор, анги дотор гэмтсэн цахилгааны залгуур байхгүй, залгуур хамгаалалттай<br>9. Сургуулийн цайны газартай ч ариун цэвэр, халдвар хамгааллын горим мөрддөг ч хоолны чанар хүүхдийн эрүүл мэндэд хоргүй, үнэ зохистой, цэвэр ус уух бололцоотой |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 9. Сургууль цайны газаргүй, цэвэр ус уух боломцоогүй | наасан, хурц үзүүртэй унах аюултай тавилга байлаг<br>8. Сургуулийн коридор, анги дотор гэмтсэн, ил гарсан цахилгааны утас, залгуур байгаа<br>9. Сургуулийн цайны газартай ч ариун цэвэр, халдвар хамгааллын горим барьдаггүй | 9. Сургуулийн цайны газартай ч ариун цэвэр, халдвар хамгааллын горим мөрддөг ч хоолны үнэ чанар муу | |
| Шалгуур 2 – Сургуулийн гадаад орчин | 1. Сургуулийн ойр 50 м дотор хамгаалалтгүй үерийн ам, далантай, өндөр хүчдэлийн шонтой, барилгын хана болон ойр ил гарсан, гэмтсэн цахилгааны утас байгаа<br>2. Сургуулийн барилга болон хашааны үүд өндөр довжоотой, цас, бороотой үед хальтирах аюултай, галын аюулгүй байдлын хэрэгсэл байхгүй<br>3. Сургуулийн ойр хур хог хаягдлын цэгтэй, задгай байдаг | 1. Сургуулийн ойр 50 м дотор үерийн ам, далантай, өндөр хүчдэлийн шонд хүүхэд нэвтрэхээс хамгаалсан.<br>2. Сургуулийн барилга, хашааны хаалга довжоотой, хальтрахгүй галын аюулгүй байдлын хэрэгсэл байдаг<br>3. Сургуулийн ойр хог хаягдлын цэг байдаг, хашаатай ч задгай хаядаг | 1. Сургуулийн барилгаас 100 м дотор үерийн ам, далан, өндөр хүчдэлийн шон байдаг, хамгаалалт сайн, аюулгүйн тэмдэглэгээ сайн.<br>2. Сургуулийн барилга, хашааны хаалга тэргэнцэртэй хүн орох боломцоотой өргөн налуу замтай, шат намхан, ойрхон галын аюулгүй байдлын хэрэгсэлтэй<br>3. Сургуулийн хог хаягдлын цэг нь салхины доор зохистой газар байдаг-тогтмол цэвэрлэдэг<br>4. Сургуулийн хашаа тэгш сараалжин, траншейний худгийн хэсэг сайтар хамгаалагдсан. | 1. Сургуулийн барилгаас 300 м дотор үерийн ам, далан, өндөр хүчдэлийн шон байхгүй<br>2. Сургуулийн бүх барилга, хашааны хаалга, тэргэнцэртэй, хараааны бэрхшээлтэй сурагчдын орох/гарах боломжийг хангасан стандарт налуу замтай, галын аюулгүй хэрэгсэл ойр байдаг.<br>3. Сургуулийн хог хаягдлыг ялган хаях сав бүхий цэг нь салхины доор зохистой газар байдаг-тогтмол цэвэрлэдэг<br>4. Сургуулийн хашаа хурц үзүүргүй сараалжин, гадна байрлах траншейний худгууд сайтар хамгаалагдсан<br>5. Сургуулийн хашааны гадна ойрхон авто замгүй, явган хүний гарцтай, гэрлэн болон дуут дохиотой, хашааны гадна, дотор машины зогсоолтой<br>6. Сургууль төвийн халаалтай, утаагүй орчинд байршдаг<br>7. Сургууль гадаа бие засах газаргүй, орчныг байнга цэвэрлэдэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 4. Сургуулийн хашаа хурц үзүүртэй, хашааны гадна болон дотор траншейны нүхтэй-таггүй<br>5. Сургуулийн хашааны гадна ойрхон авто замтай - гарц, хурд сааруулагч, гэрлэн дохио байхгүй, зогсоолгүй<br>6. Сургуулийн ойр түүхий нүүрс түлдэг их утаа гаргадаг<br>7. Сургуулийн гадна бохир бие засах газартай<br>8. Сургуулийн барилгын эргэн тойронд гэрэлтүүлэггүй<br>9. Гадна спортын талбайгүй | 4. Сургууль өндөр сараалжин хашаатай, гадна болон дотор траншейны нүхтэй-тагтай<br>5. Сургуулийн хашааны гадна ойрхон авто замтай, явган хүний гарцтай, хашааны гадна, дотор машины зогсоолтой<br>6. Сургуулийн ойр уурын зуухтай, утаа ихтэй<br>7. Сургуулийн гадна бага болон дунд ангийн хүүхэд, эрэгтэй эмэгтэй хүүхдэд зориулсан ариутгаж цэвэрлэдэг, хаалгатай, гэрэлтэй, бие засах газартай<br>8. Сургуулийн барилгын эргэн тойронд гэрэлтүүлэгтэй<br>9. Гадна спортын талбайтай- хашаа хамгаалалт муу, хичээллийн хэрэгсэл эвдэрсэн | 5. Сургуулийн хашааны гадна ойрхон авто замгүй, явган хүний гарцтай, гэрлэн дохиотой, хашааны гадна, дотор машины зогсоолтой<br>6. Сургуулт төвийн халаалттай ч утаа ихтэй орчинтой<br>7. Сургууль гадаа бие засах газаргүй ч зарим хүмүүс ил бие засдаг булан тохой бий<br>8. Сургуулийн барилгын болон хашааны эргэн тойронд гэрэлтүүлэгтэй, явган хүний засмал замтай<br>9. Гадна спортын талбайн хэрэгслүүд хашаа хамгаалалт сайтай | 8. Сургуулийн барилга хашааны гадна гэрэлтүүлэгтэй, гадна орчныг баримтжуулах камертай<br>9. Гадна спортын талбайн хэрэгслүүд хүүхдэд аюулгүй байдлыг бүрэн хангасан |

<table>
<tr><td></td><td colspan="2"></td><td colspan="2"></td><td colspan="2"></td><td colspan="2"></td></tr>
<tr><td>Шалгуур 3 – Дотуур байр</td><td colspan="2">1. Хүүхэд бүрт ор байдаг ч ширээ, сандал, хувцасны шүүгээ байхгүй<br>2. Гадна бие засах газартай, дотуур байрнаас хол, бохир, гар угаалтуур хүрэлцээгүй, хувцас угаах индүүдэх өрөөгүй<br>3. Сургууль, гадаа жорлон хүрэх замгүй, гэрэлтүүлэггүй<br>4. Байранд хөгжлийн тэнгэнцэртэй хүүхэд орох, амьдрах ямар ч бололцоогүй<br>5. Хичээл давтах өрөө байхгүй<br>6. Гал тогоо зориулалтын бус, хол байрладаг</td><td colspan="2">1. Хүүхэд бүрт ор байдаг ч ширээ, сандал, хувцасны шүүгээ хүрэлцээгүй, эвдэрч хуучирсан<br>2. Гадна бие засах газартай, дотуур байртай ойр ч бага насны хүүхдэл тохиромжгүй, хаалга түгжээгүй, гар угаалтуур үүдэнд байдаг, хувцас угаах индүүдэх өрөөгүй<br>3. Сургууль, гадаа жорлон хүрэх замтай ч гэрэлтүүлэггүй<br>4. Байр налуу замтай орцтой ч, амьдах өрөө тохиромжгүй бололцоогүй<br>5. Хичээл давтах өрөө байдаг ч байнга онгорхой байдаггүй<br>6. Гал тогоо зориулалтын байранд байдаг ч зөөврийн устай</td><td colspan="2">1. Хүүхэд бүрт ор, ширээ, сандал хувцасны шүүгээ хүрэлцээтэй ч эвдэрч хуучирч байгаа<br>2. Дотор бие засах газартай ч бохир, усанд орох өрөөгүй, хувцас угаах индүүдэх өрөөгүй<br>3. Сургууль хүрэх хүрэх засмал замтай ч гэрэлтүүлэгтэй<br>4. Байр налуу замтай орцтой ч, нэг давхрын өрөөнд амьдрах бололцоотой<br>5. Хичээл давтах өрөө байдаг хүссэн үедээ орж болно.<br>6. Гал тогоо зориулалтын байртай ч тоног хэрэгсэл бүрэн дүүрэн ашиглах бололцоогүй</td><td colspan="2">1. Хүүхэд бүрт ор, ширээ, сандал хувцасны шүүгээ хүрэлцээтэй ч эвдэрч хуучирч байгаа<br>2. Эрэгтэй эмэгтэй хүүхдэд зориулсан дотор бие засах газартай, усанд орох өрөөтэй, хувцас угаах индүүдэх өрөөтэй<br>3. Сургууль хүрэх хүрэх засмал замтай ч гэрэлтүүлэгтэй, камертай<br>4. Байр налуу замтай орцтой ч, аль давхар өрөөнд тэргэнцэртэй, хараагүй хүүхэд амьдрах бололцоотой<br>5. Хичээл давтах өрөө, номын сан үргэлж нээлттэй, тав тухтай<br>6. Гал тогоо зориулалтын байртай, тоног хэрэгсэл бүрэн дүүрэн ашигладаг, хүүхэд, ажилтанд зориулсан гар угаалтуур, бие засах газартай</td></tr>
<tr><td>Оноо</td><td>20</td><td>30</td><td>40</td><td>50</td><td>60</td><td>70</td><td>80</td><td>100</td></tr>
<tr><td colspan="4">Үнэлгээ өгсөн үндэслэл, нотолгоо</td><td colspan="5">Сургуулийн орчныг сайжруулах, бататгах санал</td></tr>
</table>

| | |
|---|---|
| | |

2. **Нийгэм, сэтгэл зүйн орчин**

| Шалгуур\ Түвшин | 1 - Эрсдэл ихтэй | 2 - Дунд эрсдэлтэй | 3 - Бага эрсдэлтэй | 4 - Эрсдэлгүй |
|---|---|---|---|---|
| Шалгуур 1- Эерэг уур амьсгал | 1. Ангийн хүүхдүүд бүгд хоорондоо эв найрамдалгүй<br>2. Олон хүүхэд сургуульдаа явах дургүй<br>3. Сургуулиас явуулдаг хичээлээс гадуурх үйл ажиллагаа байхгүй эсвэл хүртээмжгүй<br>4. Сургуулийн багш, ажилчдын эцэг эх, хүүхэдтэй харилцаа муу, хэрүүл гомдол ихтэй<br>5. Сургуулийн ойр орчимд дарамт, дээрэлхэлд хүүхэд өртөх нь их, асуудлыг хүүхэд, эцэг эхэд бурууг өгч шийдэхгүй орхидог, эсвэл сургуулиас хөөдөг. | 1. Ангийн хүүхдүүд бүгд хоорондоо цөөн цөөнөөр нийлдэг, нийтээр эв түнжин сайнгүй<br>2. Сургуульдаа ихэнхи хүүхэд явах дуртай ч буруутгах үйлдэл хийвэл хүүхдүүд хичээл таслах нь их<br>3. Сургуулиас явуулдаг хичээлээс гадуурх үйл ажиллагаа бага цөөхөн хүүхдийг хамруулдаг<br>4. Сургуулийн багш, ажилчдын хүүхэд, эцэг эхтэй хөндий харилцаатай, бие биенээ муулдаг<br>5. Сургуулийн ойр орчимд дарамт, дээрэлхэлд хүүхэд өртдөг, асуудлыг нуун дарагдуулж, мэдэгдсэн тохиолдолд удирдлагын түвшинд шийддэг | 1. Ангийн хүүхдүүд бүгд хоорондоо эвтэй ч ангийн багшаас эмээдэг<br>2. Хүүхэд бүр сургуульдаа явах дуртай, сургуульдаа өрнөж байгаа сайн муу явдлыг чөлөөтэй ярьдаг<br>3. Сургуулиас явуулдаг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд ихэнх хүүхэд ордог ч хөгжлийн бэрхшээлтнй хүүхэд оролцох боломжгүй<br>4. Сургуулийн багш, ажилчдын хүүхэд, эцэг эхтэй харилцаа ерөнхийдөө сайн ч сургуулийн удирдлагаас эмээдэг.<br>5. Сургуулийн ойр орчимд дарамт, дээрэлхэл гарсан тохиолдолд хүүхдүүд ангийн хүрээнд шийддэг, хүүхдийг буруутгаж шийдгэдэг | 1. Ангийн хүүхдүүд бүгд хоорондоо эвтэй, бие биенээ хүндэлдэг, ангийн багштайгаа дотно<br>2. Сургуульдаа хүүхэд бүр явах дуртай, сургуулиа магтдаг, асуудал гарвал шийдвэрлэх арга замыг мэддэг<br>3. Сургуулиас явуулдаг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан тэгш оролцуулахаар зохион байгуулдаг<br>4. Сургуулийн багш, ажилчдын хүүхэд, эцэг эхтэй үргэлж найрсаг харилцаатай, асуудлыг эерэгээр шийддэг туршлагатай<br>5. Сургуулийн ойр орчимд дарамт, дээрэлхэл гарсан тохиолдолд багш, хүүхэд эцэг эхийн нэр хүндийг эрхэмлэж эерэгээр, хариуцлагатай шийдвэрлэдэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шалгуур 2- Бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл | 1. Дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүргэдэггүй<br>2. Үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой мэдээлэл бүх хүүхдэд хүргэдэггүй<br>3. Хүүхдэд таагүй мэдрэмж төрвөл, дарамт, хүчирхийлэлд өртсөн тухай сургуульд мэдээлэх газар, хүн байхгүй<br>4. Сургуулийн дотор болон гадна орчинд үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой мэдээлэл, зурагт хуудас байхгүй<br>5. Эрсдэлт зан үйл, хорт зуршилтай холбоотой мэдээллийг ангийн багш санаачилвал ангид мэдээлэл хүргэдэг ч нийтэд хүргэдэггүй. | 1. Дарамт, хүчирхийллийн талаар засгийн газраас зохион байгуулах үед өглөг<br>2. Үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээний талаар нэгдсэн хурал, уулзалтаар мэдээлдэг<br>3. Хүүхдэд таагүй мэдрэмж төрвөл, дарамт, хүчирхийллийг мэдэрвэл туслах, хандах хүн байдаг гэдэг ч хүүхэд эцэг эх мэдэхгүй.<br>4. Сургуулийн дотор болон гадна орчинд үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой мэдээлэл, зурагт хуудас үүдний мэдээллийн самбарт хадсан ч эцэг эх, хүүхдэд харагдахуйц байрлуулаагүй<br>5. Эрсдэлт зан үйл, хорт зуршилтай холбоотой мэдээллийн аяны үед л мэдээлэх арга хэмжээ зохиодог. | 1. Дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хэн нэгнээс дарамт мэдэрвэл хаашаа хандах тухай мэдээлэх нэгдсэн арга хэмжээ тогтмол зохион байгуулдаг<br>2. Үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой мэдээлэл өгөх нэгдсэн арга хэмжээ тогтмол зохион байгуулдаг<br>3. Хүүхдэд таагүй мэдрэмж төрвөл, дарамт, хүчирхийллийг мэдэрвэл туслах, хандах хүн томилсон ч хүүхэд бага очдог<br>4. Сургуулийн дотор болон гадна орчинд үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой мэдээлэл, зурагт хуудас хадсан хүүхэд, эцэг эхэд тайлбарлаагүй<br>5. Эрсдэлт зан үйл, хорт зуршилтай холбоотой урьдчилан сэргийлэх мэдлэг, нэгдсэн арга хэмжээ тогтмол зохиодог. | 1. Дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хэн нэгнээс дарамт мэдэрвэл хаашаа хандах тухай хичээлээр заадаг, яаж хамгаалахаа мэддэг<br>2. Үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой хичээлийг ордог, энэ үед яаж зогсоохыг мэддэг<br>3. Хэрэв хүүхдэд таагүй мэдрэмж төрвөл, дарамт, хүчирхийллийг мэдэрвэл туслах, хандах хүн сургуульд байдаг, хүүхдүүд эмээхгүй очдог<br>4. Сургуулийн дотор болон гадна орчинд үе тэнгийн дарамт, цахим орчны аюулгүй хэрэглээ зэрэгтэй холбоотой мэдээлэл, зурагт хуудас хүүхэд бүрт харагдахуйц газар байдаг, багш ажилчид хүүхдэд тайлбарлаж өгсөн<br>5. Эрсдэлт зан үйл, хорт зуршилтай холбоотой урьдчилан сэргийлэх мэдлэг, ур чадвар олгох хичээл ордог, эцэг эхэд таниулах арга хэмжээ тогтмол зохиодог. |
| Шалгуур 3 - Сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалт | 1. Сурагчид бие биедээ нэр хоч өгч харилцдаг, багш нар мэдсэн үл ойшоодог<br>2. Нэг нэгнийгээ шоолох, шоодворлох нь хэвийн зүйл<br>3. Ангийн хүүхдүүд нэгнийгээ зодох, шийтгэх явдал гардаг<br>4. Анги хоорондын харилцаа муу, зодоон болдог, бусад ангийн хүүхдүүд дээрэлхэх, дарамтлах, түүнээс айж, түгших явдал гардаг | 1. Сурагчид бие биедээ нэр хоч өгч харилцдаг ч багш нар мэдвэл загнадаг<br>2. Нэг нэгнийгээ багшийн хараагүй үед шоолох, шоодворлох тохиолдол гардаг<br>3. Ангийн хүүхдүүд нэгнийгээ зодох, шийтгэх явдал гардаг<br>4. Анги хоорондын зодоон маргаан болоход ангийн багш нар шийддэг | 1. Сурагчид бие биедээ нэр хоч өгч харилцахгүй байхыг багш нар тухайн хүүхдэд хэлж ойлгуулдаг<br>2. Нэг нэгнийгээ шоолох, шоодворлохгүй байхыг багш нар ангидаа мэдээлдэг<br>3. Ангийн хүүхдүүд нэгнийгээ зодох, шийтгэх явдал гардаг<br>4. Анги хоорондын зодоон, маргааны ангийн багш, эцэг эхтэй хэлэлцэн шийддэг | 1. Сурагчид бие биедээ нэр хоч өгч харилцахгүй байх талаар хичээл ордог, ангийн дүрэмд тусгасан байдаг<br>2. Нэг нэгнийгээ шоолох, шоодворлохын эсрэг ангийн дүрэмтэй, хичээлээр заадаг<br>3. Ангийн хүүхдүүд нэгнийгээ зодох, шийтгэх явдал гардаг<br>4. Анги хоорондын харилцааг бэхжүүлэх арга хэмжээ тогтмол |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 5. Сургуулийн багш, удирдлага сурагчдыг үг хэлээр ялгаварлаж шийтгэдэг | 5. Сургуулийн багш, удирдлага сурагчдыг үг хэлээр ялгаварлах тохиолдол хааяа гардаг | 5. Сургуулийн багш, удирдлага сурагчдыг үг хэлээр ялгаварладаггүй, харилцан хүндэтгэлтэй харьцдаг | зохион байгуулж хүүхдүүдийг нөхөрлүүлдэг<br>5. Сургуулийн багш, удирдлага сурагч, эцэг эхийг сайн сонсдог тул тэдэнтэй харилцахаас эмээдэггүй, |

| Оноо | 20 | 30 | 40 | 50 | 60 | 70 | 80 | 100 |
|---|---|---|---|---|---|---|---|---|

| Үнэлгээ өгсөн үндэслэл, нотолгоо | Нийгэм, сэтгэл зүйн орчныг сайжруулах, бататгах санал |
|---|---|
| | |

### 3. Засаглалын орчин

| Шалгуур\ Түвшин | 1 - Эрсдэл ихтэй | 2 - Дунд эрсдэлтэй | 3 - Бага эрсдэлтэй | 4 - Эрсдэлгүй |
|---|---|---|---|---|
| Шалгуур 1-Бодлого | 1. Сургууль нь хүүхэд хамгааллын шаардлагатай бүх бодлого журмыг бүрэн боловсруулаагүй, байгаа бодлого, журмын багш, хүүхэд, эцэг эх мэдэхгүй<br>2. “Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх (гараас гарт)” журамтай ч эцэг эх мэддэггүй<br>3. Хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээлэл ирүүлсэн мэдээлэгчид хор хөнөөл учруулахгүй хүлээн авах, шалгах, мэдээллийн мөрөөр шуурхай арга | 1. Сургууль нь хүүхэд хамгааллын бүх шаардлагатай бодлого журмын боловсруулж баталж баримтжуулсан ч багш, хүүхэд, эцэг эх холбогдох бодлогыг мэдэхгүй<br>2. “Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх (гараас гарт)” журамтай ч сайн хэрэгждэггүй<br>3. Хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээлэл ирүүлсэн мэдээлэгчид хор хөнөөл учруулахгүй хүлээн | 1. Сургууль нь хүүхэд хамгааллын бүх шаардлагатай бодлого журмын боловсруулж баталж мэдээллийн самбарт хадсан.<br>2. “Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх (гараас гарт)” журам багш нар баримталдаг<br>3. Хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээлэл ирүүлсэн мэдээлэгчид хор хөнөөл учруулахгүй хүлээн авах, шалгах, мэдээллийн мөрөөр | 1. Сургууль нь хүүхэд хамгааллын бүх шаардлагатай бодлого журмын боловсруулж баталж мэдээллийн самбарт хадсан. Хүүхэд, эцэг эхэд ойлгомжтой байдлаар тогтмол танилцуулдаг.<br>2. “Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх (гараас гарт)” журам ягштал баримталж танихгүй хүн ирэхэд эцэг эхээс лавладаг<br>3. Хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээлэл ирүүлсэн мэдээлэгчид хор хөнөөл учруулахгүй хүлээн авах, шалгах, мэдээллийн мөрөөр шуурхай арга хэмжээ авах тухай “Мэдээллийн журам”-ыг хүн бүр мэддэг, хэрэгжүүлсэн туршлагатай<br>4. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэмжээ авах тухай "Мэдээллийн журам"байхгүй | авах, шалгах, мэдээллийн мөрөөр шуурхай арга хэмжээ авах тухай "Мэдээллийн журам" нийгмийн ажилтанд байдаг ч хүүхэд, эцэг эх мэдэхгүй | шуурхай арга хэмжээ авах тухай "Мэдээллийн журам" баталж нийтэд мэдээлсэн байдаг. | |
| Шалгуур 2- Хэрэгжилт | 1. Тухайлсан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй.<br>2. Дотуур байрны журамд ерөнхий агуулгатай, мэдээллийн самбарт хадсан ч хүүхэд, эцэг эх мэдэхгүй<br>3. Дотуур байр, эцэг эх, хүүхдийн үүрэг хариуцлагыг тусгасан 3 талт гэрээг байгуулдаггүй<br>4. Хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдээлэл хэн ч өгдөггүй.<br>5. Хүүхдийн оролцооны байгууллага ажиллах өрөөгүй<br>6. Хүүхдэд байгалийн гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургалт зохиодоггүй<br>7. Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, зүй бус хандлага, гэмт хэрэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай сургуулийн | 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталсан<br>2. Дотуур байрны журамд гадны хүн байрлуулахгүй байх, гадны хүн нэвтрэхэд баримтлах дэгийг тусгасан<br>3. Дотуур байр, эцэг эх, хүүхдийн үүрэг хариуцлагыг тусгасан 3 талт гэрээ байгуулдаг ч ёс төдий байдаг<br>4. Нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдээлэл хадсан<br>5. Хүүхдийн оролцооны байгууллага ажиллах өрөөтэй ч нийгмийн ажилтны өрөө болгож ашигладаг<br>6. Хүүхдэд байгалийн гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах төлөвлөгөө байдаг ч хэрэгжүүлдэггүй | 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, үйл ажиллагаа нь оновчтой бус<br>2. Дотуур байрны журамд гадны хүн байрлуулахгүй байх, гадны хүн нэвтрэхэд баримтлах дэгийг тусгасан ч мөрдөхгүй тохиолдол байдаг<br>3. Дотуур байр, эцэг эх, хүүхдийн үүрэг хариуцлагыг тусгасан 3 талт гэрээ хийсэн ч эцэг эхэд хувийг өгдөггүй<br>4. Сургуулийн захирал нь нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай багш, ажилтанд хичээлийн жилийн эхэнд мэдээлсэн.<br>5. Хүүхдийн оролцооны байгууллага ажиллах өрөөтэй ч хүүхдүүд | 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв зардлыг шийдсэн, тогтмол зохион байгуулдаг<br>2. Дотуур байрны журамд гадны хүн байрлуулахгүй байх, гадны хүн нэвтрэхэд баримтлах дэгийг тусгасан, ягштал мөрддөг<br>3. Дотуур байр, эцэг эх, хүүхдийн үүрэг хариуцлагыг тусгасан 3 талт гэрээ байгуулж эцэг эх хүүхдэд хувийг өгч зөрцсөн тохиолдолд сануулдаг.<br>4. Сургуулийн захирал нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ажлын байран дахь сургалтыг нийт багш, ажилтанд улирал тутам зохион байгуулсан<br>5. Хүүхдийн оролцооны байгууллага ажиллах өрөөтэй, хүүхдүүд өөрсдийн санаачлагаар үйл ажиллагаа өрнүүлдэг<br>6. Хүүхдэд байгалийн гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургах тогтмол үйл ажиллагаа бүх хүүхдийг хамарч зохион байнуулдаг<br>7. Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, зүй бус хандлага, гэмт хэрэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой дүрмийг анги бүрт хүүхдийн оролцоотой зохиож, шаардлагатай нөхцөлд ганцаарчилсан хөтөлбөр хэрэгжүүлдэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | болон ангийн дүрэмд тусгаагүй байдаг.<br>8. Нөхөрсөг харилцааны талаар ангийн багш санаачилвал ангидаа сургалт үйл ажиллагаа зохиодог.<br>9. Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтардаггүй. | 7. Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, зүй бус хандлага, гэмт хэрэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой дүрмийг нийгмийн ажилтан боловсруулан батлуулсан ч хүүхэд бүр мэдэхгүй<br>8. Нөхөрсөг харилцааны талаар сургалт нийтийн арга хэмжээний үеэр олгодог<br>9. Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллага өөрсдөө ирвэл танилцуулдаг | тогтмол ажил зохиодоггүй.<br>6. Хүүхдэд байгалийн гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургалтыг ёс төдийг зохион байгуулдаг<br>7. Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, зүй бус хандлага, гэмт хэрэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай хичээлээр ордог<br>8. Нөхөрсөг харилцааны талаар сургалт хүүхдэд ордог<br>9. Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтарсан арга хэмжээ зохион байгуулдаг | 8. Нөхөрсөг харилцааны талаар сургалт хүүхэд, эцэг эхэд тогтмол ордог.<br>9. Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтарсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлдэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шалгуур 3 – Хяналт | 1. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагааны тайлан байдаггүй<br>2. Багшийн ёс зүйн дүрэм байдаг ч бүх багш, ажилтанд танилцуулж, гарын үсэг зуруулаагүй<br>3. Сэтгэл зүйч байхгүй, нийгмийн ажилтан зөвлөгөө өгөх ур чадваргүй.<br>4. Хүүхэд, эцэг эх хүүхдийн эрхийн зөрчлийн талаар мэдээлэх саналын хайрцгийг нийтийн хэсэгт байршуулсан, санал, гомдлыг хэрхэн шийдэх нь тодорхойгүй<br>5. Сургууль, дотуур байрны багш, ажилтан, ажилчин ажилд авахдаа цагдаагийн тодорхойлолтыг авдаг<br>6. Сургууль, дотуур байрын орчны эрсдэлийн үнэлгээ хийдэггүй | 1. Хүүхэд хамгааллын чиглэлээр тогтмол үйл ажиллагаа зохион байгуулдаггүй ч тайланд тусгадаг<br>2. Багшийн ёс зүйн дүрмийн заалтуудыг багш, ажилтанд зориулсан мэдээллийн самбарт хадсан байдаг<br>3. Сэтгэл зүйч байхгүй, нийгмийн ажилтан энэ үүргийг хүлээдэг<br>4. Хүүхэд эцэг эх хүүхдийн эрхийн зөрчлийн талаар мэдээлэх санал гомдлын хэсэгтэй ч хүүхэд үйлчлүүлдэггүй<br>5. Сургууль, дотуур байрны удирдах ажилтан, багш, ажилтан, ажилчин ажилд авахдаа цагдаагийн тодорхойлолтыг авдаг<br>6. Сургууль, дотуур байрын орчны эрсдэлийн үнэлгээг нийгмийн ажилтан хийсэн ч олон нийтэд мэдээлдэггүй | 1. Хүүхэд хамгааллын чиглэлээр тогтмол үйл ажиллагаа зохион байгуулдагч үр дүнг тооцдоггүй<br>2. Багшийн ёс зүйн дүрмийн заалтуудыг бүх багш, ажилтанд танилцуулж, зөвшөөрсөн гарын үсэг зуруулсан<br>3. Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг ч тусгай хэрэгцээг хангасан өрөөгүй<br>4. Хүүхэд эцэг эх хүүхдийн эрхийн зөрчлийн талаар саналын хайрцаг, утасны цэгтэй ч чөлөөтэй үйлчлүүлэх боломж муу<br>5. Сургууль, дотуур байрны удирдах ажилтан, багш, ажилтан, ажилчин, сайн дурын ажилтан ажилд авахдаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг нотлох эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг авдаг<br>6. Сургууль, дотуур байрын орчны эрсдэлийн үнэлгээг нийгмийн ажилтан багш нартай хэлэлцэн хийж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг. | 1. Хүүхэд хамгааллын чиглэлээр тогтмол үйл ажиллагаа зохион байгуулсны үр дүнг тооцсон<br>2. Багшийн ёс зүйн дүрмийн заалтуудыг бүх багш, ажилтанд танилцуулж, зөвшөөрсөн гарын үсэг зуруулсан, ёс зүйн хороо ажилладаг.<br>3. Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг, үйлчилгээ тусгай хэрэгцээг хангасан<br>4. Хүүхэд эцэг эх хүүхдийн эрхийн зөрчлийн талаар мэдээлэх саналын хайрцаг, утасны цэгтэй, тэр нь тусгай хэрэгцээг хангасан, хариуг даруй өгдөг<br>5. Сургууль, дотуур байрны удирдах ажилтан, багш, ажилтан, ажилчин, сайн дурын ажилтан ажилд авахдаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг нотлох эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг заавал авдаг, сонгон шалгаруулах үзүүлэлтэд оруулсан<br>6. Сургууль, дотуур байрын орчны эрсдэлийн үнэлгээг тогтмол жил бүр багш, ажилтан, хүүхэд эцэг эхийг хамруулж хийдэг, үнэлгээний дагуу үйл ажиллагаа зохион байгуулдаг |

| Оноо | 20 | 30 | 40 | 50 | 60 | 70 | 80 | 100 |
|---|---|---|---|---|---|---|---|---|

| Үнэлгээ өгсөн үндэслэл, нотолгоо | Засаглалын орчныг сайжруулах, бататгах санал |
|---|---|
| | |

***4 дүгээр үе - Үнэлгээг нэгтгэх, зөвлөмж төлөвлөгөө боловсруулах***

1. Үнэлгээг оролцогч бүрийн оноог шалгуур тус бүрээр нэгтгэн дунджаар үнэлэн дараах загварт оруулан зураглана.

| Хүрээ | Шалгуур 1 | Шалгуур 2 | Шалгуур 3 | Нийлбэр онооны дундаж |
|---|---|---|---|---|
| ***Сургуулийн орчин*** | | | | |
| ***Нийгэм, сэтгэл зүйн орчин*** | | | | |
| ***Засаглалын орчин*** | | | | |




2. Ерөнхий дүгнэлт ба сургуулийн орчинд хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлыг бууруулах зөвлөмж боловсруулна. Зураглалаас хамгийн бага оноо авсан орчны эрсдлийг бууруулах болон арилгах алхамуудын талаарх саналаа нэгтгэн "Сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгах санал зөвлөмжийг нийт оролцогчид боловсруулан сургуулийн удирдлага, эцэг эхийн зөвлөл, сурагчдад нээлттэй танилцуулна.
3. Ирэх хичээлийн жилийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

**ХАВСРАЛТ**

# Материаллаг орчны үнэлгээний хуудас

### Ажиглалтын хуудас бөглөх заавар

Үнэлгээний багийн гишүүд сургууль, дотуур байрны дотоод болон гадаад орчинд тэгш хамруулахуйн үзэл баримтлалаар ажиглалт хийнэ. Асуулгын дагуу ажиглалт “Тийм”, “Үгүй” гэсэн хариултын аль тохирох хэсэгт “+” тэмдэглэгээг бичнэ. Нэмэлтээр тайлбар бичих бол “Тэмдэглэл” хэсэгт бичээрэй. Энд дэлгэрэнгүй бичиж тэмдэглэх нь дараа нь үнэлгээний дүнг нэгтгэхэд чухал ач холбогдолтойг анхаарна уу.

### 1.Сургуулийн орчин

| № | Аюулгүй байдлын үзүүлэлт | Тийм | Үгүй | Тэмдэглэл |
|---|---|---|---|---|
| **Сургуулийн гадна орчин** | | | | |
| 1 | Сургуулийн ойр үерийн ам, далантай | | | |
| 2 | Сургуулийн ойр өндөр хүчдэлийн шонтой | | | |
| 3 | Сургуулийн ойр хур хог хаягдлын цэгтэй, тогтмол ачил хийдэггүй | | | |
| 4 | Сургуулийн хашаанаас 150 хүртэлх метрийн зайнд гадна болон дотор талд траншейны таггүй нүх, хамгаалалтын хашаа хаалтгүй гүнзгий нүх, суваг байгаа | | | |
| 5 | Сургуулийн ойр түүхий нүүрс (сайжруулсан түлш) түлдэг уурын зуухтай | | | |
| 6 | Сургуулийн барилгын хана болон ойр ил гарсан, гэмтсэн цахилгааны утас байгаа | | | |
| 7 | Сургуулийн хашаан дотор хаалтгүй машины зогсоолтой | | | |
| 8 | Сургуулийн хашаанаас 50 м дотор авто замтай | | | |
| 9 | Авто зам явган хүний гарцтай | | | |
